



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2024/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудиын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1.2 Албан шаардлага.....	8
3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	162

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БХС	Байгаль хамгаалах сан
МХС	Мал хамгаадах сан
ОННТ	Орон нутгийн нэгтгэсэн тайлан

1.Аудиын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭРЭН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Л.АМАРТҮВШИН ТАНАА

2024-03-25 № 117
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Дэрэн сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар эд хөрөнгийн хагас жилийн тооллого хийгээгүй, жилийн эцсийн тооллогыг чанаргүй хийсэн, тооллогын явцад хяналт тавиагүй, санхүүгийн тайлан дахь үндсэн хөрөнгийн дүн 6.2 сая төгрөгөөр, бараа материалын дүн 3.8 сая төгрөгөөр тооллогын бүртгэлээс зөрүүтэй, тооцоог бодож, баталгаажуулаагүй, мөн 2023 онд байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа 3 авто машинд зарцуулсан шатахууныг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулаагүй байна.
2. Орон тоо, цалингийн сан батлагдаагүй албан тушаалд ажилтан авч ажиллуулсан, урамшуулалт цалин илүү тооцож олгосон
3. Хоршоо хөгжүүлэх сангаас 2023 онд 15.0 сая төгрөгийн зээл авсан зээлдэгч О.Нанжид /Үсчин гоо сайхан/, Б.Дожсамбуу /Хоёрдогч түүхий эд/ нарын зээлийн ашиглалт хангалтгүй, төсөлд дурдагдсан чиглэлээр огт үйл ажиллагаа явуулаагүй, тоног төхөөрөмжийг худалдан авсан эсэх нь тодорхой бус байгаа нь зээлийг зориулалт бусаар зарцуулж санд хохирол учруулсан байх эрсдэлтэй.
4. ИТХ-ын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид 0.8 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг үндсэн байгууллагатай нь давхардуулж тооцон олгосон.

5. Мал хамгаалах сангийн тайланд дахь байгууллага хувь хүмүүсээс авах 18.1 сая төгрөгийн авлагыг өр, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 13 дугаар зүйлийн 13.1. дэх заалт, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дүгээр тушаалын 1-р хавсралт, Хоршооны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.9, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4, 3.4.2, 3.4.3-дахь заалт, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16.5.2 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6-дахь заалтуудтай нийцэхгүй, нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Залруулагдаагүй алдаа нь урьдчилан тооцоолсон материаллаг байдлын түвшнээс 3.8 дахин их, үндсэн хөрөнгө, бараа материалын дүн тооллогын бүртгэлээс зөрүүтэй, тооцоог бодож, баталгаажуулаагүй, шатахууны зардлыг хяналтгүй зарцуулж, зарцуулалтын тооцоог бодож баталгаажуулаагүй, бусад үндсэн хөрөнгийн зардлаас санхүүжүүлсэн 43.7 сая төгрөгийн өртөгтэй “Соёлын төвийн засвар”-ын ажлын худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, шууд худалдан авалт хийсэн зэрэг зөрчил нь шинж чанар агуулгын хувьд материаллаг, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, эрх үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 122.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 22.1 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Өндөршил сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын 2023 оны татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 2.2 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр, орлогын төрлөөрөө 9 нэр төрлийн орлого 49.5 сая төгрөгөөр тасарсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчил нь тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 23 зорилт, 125 арга хэмжээг хэрэгжүүлэхээс 113 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 89.3 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	879,295.10	808,352.80
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	578,642.40	400,504.80
33	АВЛАГА	97,598.80	163,375.00
35	БАРАА МАТЕРИАЛ	193,053.80	234,472.90
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10,000.00	10,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	840,481.00	866,807.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	840,481.00	866,807.20
39200	Биет хөрөнгө	837,873.40	857,990.00
39300	Биет бус хөрөнгө	2,607.60	8,817.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,719,776.10	1,675,160.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,960.60	3,120.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,960.60	3,120.60
41300	Өглөг	3,960.60	3,120.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,715,815.50	1,672,039.50
51	Засгийн газрын хувь оролцоо	1,715,815.50	1,672,039.50
51100	Засгийн газрын оруулсан капитал	415,427.20	415,427.20
51200	Хуримтлагдсан үр дүн	1,200,984.40	1,157,208.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	99,404.00	99,404.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,719,776.10	1,675,160.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,154,175.10	1,393,032.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	386,891.10	321,167.20
110	Орлогын албан татвар	132,383.00	152,119.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	132,383.00	152,119.00
113	Хөрөнгийн албан татвар	78,679.40	99,095.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	175,828.70	69,952.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,566.30	274,427.80
120	Нийтлэг татварын бус орлого	117,566.30	274,427.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	649,717.70	797,437.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	807,901.70	953,675.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	807,901.70	953,675.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	500,865.30	694,729.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	210,045.00	332,946.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,043.60	40,328.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,083.20	16,418.90
2104	Хангамж, бараа материалын зардал	55,753.00	74,537.30
2105	Нормативт зардал	35	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,167.50	47.4
2107	Томилолт, зочны зардал	7,200.00	13,520.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,252.90	12,623.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	163,285.00	204,307.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	307,036.40	258,945.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	346,273.40	439,357.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,314,197.00	478,539.20

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,967,923.60	-39,182.00
-----------	------------------------------------------------------------	----------------------	-------------------

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,777,539.40	6,777,539.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-93,800.20	-93,800.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,683,739.20	6,683,739.20
9	Тайлант үеийн үр дүн	-4,967,923.60	-4,967,923.60
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,715,815.50	1,715,815.50
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,715,815.50	1,715,815.50
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,594.00	-4,594.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,711,221.50	1,711,221.50
19	Тайлант үеийн үр дүн	-39,182.00	-39,182.00
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,672,039.50	1,672,039.50

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,112,016.00	1,255,379.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	386,891.10	321,167.20
110	Орлогын албан татвар	132,383.00	152,119.00
1100	Хувь хүний орлогын албан татвар	132,383.00	152,119.00
113	Хөрөнгийн албан татвар	78,679.40	99,095.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	175,828.70	69,952.30
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,320.10	8,142.00
1181	Газрын төлбөр	12,358.60	19,975.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	157,150.00	41,835.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	82,683.90	142,419.90
120	Нийтлэг татварын бус орлого	82,683.90	142,419.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	642,441.00	791,792.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	714,360.40	822,802.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	714,360.40	822,802.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	640,175.20	787,944.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	253,326.50	334,686.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,590.40	40,328.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	183,921.50	16,418.90
2104	Хангамж, бараа материалын зардал	33,207.70	37,017.20
2105	Нормативт зардал	35	645
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,174.80	2,814.50
2107	Томилолт, зочны зардал	7,200.00	13,520.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,851.20	234,217.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,868.10	108,296.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,185.20	34,857.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	397,655.70	432,576.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	322,739.40	504,714.30

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	322,739.40	504,714.30
2200	Дотоод эх үүсвэрээр	322,739.40	504,714.30
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-322,739.40	-504,714.30
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0	-106,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	106,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	74,916.20	-178,137.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	503,726.20	578,642.40
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	578,642.40	400,504.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,819,047.40	1,394,415.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,027,668.70	783,700.76
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,006,443.70	762,775.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урашил	347,165.00	334,686.32
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,137.50	40,328.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	222,582.70	216,546.95
2104	Хангамж, бараа материалын зардал	36,744.60	29,376.83
2105	Нормативт зардал	650.00	645.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,895.10	22,110.80
2107	Томилолт, зочны зардал	15,655.00	12,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,004.70	1,668.54
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	304,609.10	104,972.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,225.00	20,925.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,225.00	20,925.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	607,738.70	504,714.28
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	183,640.00	106,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,819,047.40	1,319,699.50
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	249,503.50	249,503.50
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,040,561.50	975,053.49
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	528,982.40	95,142.51
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	408,233.12
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	333,517.58

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /мянган төгрөгөөр/

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Гүйцэтгэл
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	31,348.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,348.29
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,923.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,899.20
2104	Хангамж, бараа материалын зардал	7,640.40
2107	Томилолт, зочны зардал	1,080.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,225.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,078.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,425.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,425.29
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	31,348.29
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	31,348.29

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилт, татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой нийт **49,488.5** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүллээ.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар татварын орлогын бүрдүүлэлт, өр авлагын барагдуулалт, баталгаажуулалттай холбоотой **49,488.5** мянган төгрөгийн зөрчил² илрүүлж зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага хүргүүлсэн.

3.1.2 Албан шаардлага

- 2023 оны татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 2.2 хувиар буюу 8,882.4 мянган төгрөгөөр, орлогын төрлөөрөө 9 нэр төрлийн орлого 49,488.5 мянган төгрөгөөр дутуу биелүүлж, татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний биелэлтийн хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.-т /санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;/, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19. -д /нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;/, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.30.-д /"татварын улсын байцаагч" гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээн авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг;/ заасныг тус тус зөрчсөн;

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 5 тусгай сангийн нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1				1		
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3	Мал хамгаалах сан	1		1				
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1				
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1				
6	Байгаль хамгаалах сан	1		1				
7	Техникийн хяналтын сан	1		1				
	НИЙТ	7	1	6		1		

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 380,042.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 19,950.0 мянган төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 2,860.0 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 355,620.7 мянган төгрөгийн 15 зөрчлийг арилгах албан шаардлага, 1,612.0 мянган төгрөгийн 2 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 95.4 хувийг залруулагдаагүй, 4.6 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийн үндэслэл

Тайлбар: Төсөвт байгууллага, тусгай зориулалтын сангуудын 2023 санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар ЗДТГ-т хүргүүлсэн **62,700.8** мянган төгрөгийн 1 албан шаардлага, Хоршоо хөгжүүлэх санд хүргүүлсэн **15,000.0** мянган төгрөгийн 1 албан шаардлага, Орон нутгийн хөгжлийн санд хүргүүлсэн **228,018.3** мянган төгрөгийн 2 албан шаардлага, Засаг даргад хүргүүлсэн **49,488.5** мянган төгрөгийн 1 албан шаардлага буюу нийт **355,207.6** мянган төгрөгийн зөрчлийг нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хамруулан авч үзлээ. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулахдаа боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх **54,373.6** мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшингээс **40,068.5** мянган төгрөгөөр буюу **3.8** дахин их байна.

Иймд Дэрэн сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэрэн сумын МХС	1	19,950.0	1	19,950.0			1	19,950.0				
Дүн	1	19,950.0	1	19,950.0	-	-	1	19,950.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дэрэн сумын ИТХ	3	2,878.7	1	814.60	1	452.1	1	1,612.0				
Дэрэн сумын ЗДТГ	8	32,174.5	2	845.4	5	31,329.1	1					
Дэрэн сумын ОНХС	1	1,200.0	1	1,200.0								
Дэрэн сумын МХС	1	18,120.4			1	18,120.4						
Дүн	13	54,373.6	4	2,860.0	7	49,901.6	2	1,612.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтгүй холбоотой зөрчил													
Дэрэн сумын ИТХ	1	-			1								
Дэрэн сумын ЗДТГ	1	-	-	-					1				
Дүн	2	-	-	-	1	-	-	-	1	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил													
Дэрэн сумын ЗДТГ	2	62,700.8			2	62,700.8							
Дэрэн сумын СХС	2	15,000.0			2	15,000.0							
Дэрэн сумын ОНХС	2	228,018.3			2	228,018.3							
Дэрэн сумын ОННТ	1	49,488.5			1	49,488.5							
Дүн	7	355,207.6	-	-	7	355,207.6	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	9	355,207.6	-	-	8	355,207.6	-	-	1	-	-	-	-